



**ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН  
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ**

2020 оны 12 сарын 04 өдөр

Дугаар А/530

Арвайхээр

**Газар эзэмших эрх шинээр олгох тухай**

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2, Газрын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.3.2, 33 дугаар зүйлийн 33.1.1 дэх заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Арвайхээр сумын 13 дугаар баг Т.Намнансүрэнгийн 7 дугаар гудамж Ерөнхий боловсролын 5 дугаар сургуулийн баруун талд 737 тоотод 3000м<sup>2</sup> газрыг музей, түүх, соёлын дурсгалт газрын зориулалтаар аймгийн Музей (9045961)-д 60 жилийн хугацаатай газар эзэмших эрх олгосугай.

2. Энэ захирамж гарсантай холбогдуулан аймгийн Засаг даргын “Газар эзэмших эрх шинээр олгох тухай” 2020 оны А/07 дугаар захирамжийг хүчингүй болсонд тооцсугай.

3. Дээрх газар эзэмших эрх авсан байгууллагатай газар эзэмших гэрээг байгуулж, эрхийн гэрчилгээ олгон, газрын улсын бүртгэлд бүртгэхийг аймгийн Засаг даргын дэргэдэх Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар (Ч.Гүнсэнхорол)-т үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



А.ИШДОРЖ

011101203